

1368 онд Монголын эзэнт гүрэн мөхсөний дараа Монгол хаад эх орондоо буцаж ирээд хуучин Нийслэл Хархорум хотод эргэж төвлөн нийслэллэсэн юм. XIV-XVIII зууны үеийн Монгол улсад феодалын тархай бутархай байдал зонхилж байсан боловч түүнийг даван туулж, нэгдмэл байдлаа сэргээх оролдлого удаа дараалан хийгдэж, заримдаа тодорхой амжилт олж байжээ.

Тухайн үеийн Монгол улсын өмнөд хил нь Хятадын Цагаан хэрэмд тулж, умард хязгаар нь Байгаль нуур хүрч байхад урьдын монгол угсааны Кидан нарын үлдэгдэл болон харчин, түмэдүүдийн нутаг нь Луух голын доод урсгалаар Бохайн булан, Шар тэнгисийн бараа харж, Ойрад монгол нь Алтайн чанад дахь Или, Тарбагатай, Бор талаар нутаглаж байв. Олонх хүмүүс Зүүн Азид Монголын зүүн талаар Хятад, Манж угсаатан зах нийлж байсан мэт санадаг боловч үнэн хэрэг дээрээ эрт дээр үеэс Кидан, дараа нь харчин, түмэд, аухан (ухуа нь), Найман, Баарин зэрэг Жу-удын чуулганы монголчууд хэзээнээс янагш Манж, Хятад нутгийн завсар дахь өргөн уудам нутагт идээшин амьдарч тэнгис, далайн мандалтай танил болсон байв. Гэвч бусад олонх монголчууд Зүүн, Баруун монголын дийлэнх ихэнх нь тэнгис, далайгаас алсалсан, эх газрын эрс тэс уур амьсгалтай Төв Азийн уудам нутгийн энд тэнд нүүдлийн мал аж ахуй эрхэлж, нүүдлийн соёл иргэншил бүрэлдүүлж, оршин амьдарсаар ирсэн нь мэдээж хэрэг.

XIV зууны дэд хагаст Тогоонтөмөр (1370 онд нас барсан), Билигт (1370—1378), Төгстөмөр (1378—1388) хааны үед Монгол улс Зүүн Монголын зургаан түмэн, Баруун Монголын Дөрвөн түмнээс бүрдэж, нэгдмэл байдлаа хадгалж байв. Харин 1389 онд Зүүн Монголын Нагачу тэргүүтэй урианхай түмэн Хятадын Мин улстай байлдаж ялагдаад түүнд бууж өгсөн, 1399 онд дөрвөн ойрад нь Зүүн Монголоос тусгаарлан салснаар Монголд феодалын бутрал эхэлж, үе үе ихээхэн хүнд байдалд орж байжээ. Монгол улс анх тийнхүү Баруун Монгол буюу дөрвөн Ойрад, Зүүн Монголын зургаан түмэн болж хоёр хуваагдаад дараа нь Зүүн Монгол нь бас Зүүн гурван түмэн, баруун гурван түмэн болж хуваагдан байв. Зүүн, Баруун, түмэн, Ойрад гэж Монгол улс гурван том ханлиг буюу жижиг хант улсууд болон хуваагдаж байсан нь Монгол улсын нэгдмэл байдлыг алдагдуулж, түүний улс төр, эдийн засаг, соёлын хөгжилд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх болсон юм. Чингисийн угсааны их, хаад Монгол улсыг нийтэд нь захирч байсан нэртэй боловч Ойрадыг бага ханы эрх мэдэл бүхий тайш цолтой захиран тусгаарласан байв. Зүүн Монголын баруун гурван түмний толгой дээр нийт Монголын хааныг залгамжлах жонон цолтой хан хөвгүүн нэлээд их эрх мэдэлтэй захирч бас л биеэ даах байдалтай байжээ. Монгол улсын хаан нь, үндсэндээ зөвхөн зүүн гурван түмнийг толгойлж, гол төлөв хуучин Хархорумын ор суурин дээр өргөө ордоо босгон нийслэллэж, зарим үед Цахар түмний нутагт нүүдлийн өргөө босгож, урт богино хугацаагаар тэнд байдаг болж байжээ. Гэсэн ч ихэнх тохиолдолд Зүүн, Баруун түмний хан, ноёд Монголын хааны захиргааг ёс төдий ч гэсэн эрхбиш зөвшөөрөн хүлээсэн дүр үзүүлэхэд хүрдэг байв.

Монгол улсын нэгдмэл байдлыг сэргээх оролдлого Чингисийн угсааны хан болон хүч нөлөө бүхий бусад хан, тайш нарын зүгээс хэд хэдэн удаа нэлээд амжилттай хийгдэж байсан бөгөөд анхны тийм оролдлогын нэг нь Дундад Азийн хүчирхэг байлдан дагуулагч, Цагадайн угсааны эмип (хан) Доголон Төмөрийн ордонд байгаад тэндээс хүргэгдэн ирж 1402 онд Монголын хаан болсон Буняшир хэмээх Буняшрийн үйл ажиллагаа байв.<sup>1</sup> Буняшрийг Монголын хаан болмогц Хятадын Мин улсын засгийн газар хүлээн зөвшөөрсөнгүй, нэн даруй дагаар орохыг удаа дараалан шаардаж, хүнд байдалд оруулжээ. 1405 онд Доголон Төмөр гэнэт их цэрэг удирдан Мин улсын эсрэг аян дайнд мордсон нь Монгол дахь түүний төлөөний этгээдийн үүрэг гүйцэтгэж байсан Буняшир Хятадын зүгээс дарамт үзүүлсэн явдалтай холбоотой байж ч юуны магад. Гэвч Доголон Төмөр аян замдаа нас барж, Буняшир хаан гаднын хүчирхэг өмөг түшгээсээ хагацсан байна. 1409 онд Мин улсын Юнло хаан Монголд их цэрэгтэй цөмрөн орж, хүчтэй цохилт өгөөд буцсан, Буняшир Баруун Монголд зугтаж очоод алагдсан байна.

Монгол улсын нэгдмэл байдлыг сэргээх хоёр дахь удаагийн оролдлогыг Ойрадын Тогоон тайш (1422--1439), түүний хөвгүүн Эсэн тайш (1439—1455) нар хийжээ. Тогооны оролдлого амжилттай болсонгүй, харин Эсэн тайш амжилт олсон боловч төдийлэн баттай байсангүй. Эсэн тайш Монголжин Урианхай нарыг Хятадын хараат байдлаас гаргаж, Мин улстай байлдан, хааныг нь олзлон авч нэг үе нийт Монголыг нэгтгэн захираад биеэ хаан хэмээн өргөмжилсөн байна. Гэвч Чингисийн угсааны хүн биш байсан болохоор дэмжлэг олсонгүй байсаар эцэст нь Зүүн, Баруун Монгол ноёдын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч амь үрэгдсэн байна.

Зүүн. Баруун Монголын нэгдлийг сэргээх талаар XV зууны дэд хагас, XVI зууны эхээр Мандухай Сэцэн хатан (1433 онд төрсөн), Батмөнх даян хаан (1466—1504) нарын хийсэн тэмцэл нэлээд амжилт олсон юм.<sup>2</sup> Батмөнх Даян хааны хөвгүүдийн үед Монголын төрийн нэгдмэл байдал хадгалагдсан боловч дараа нь бас л феодалын бутралд дахин нэрвэгдсэн байна.

Монголын төрийн нэгдлийг сэргээн бэхжүүлэх их үйлсэд Түмэн Засагт хаан (1558-1593) олон шинэ зүйл сэдэж, өвөрмөц үйл ажиллагаа явуулсан нь нэг хэсэгтээ үр дүнтэй болсон юм. Түүний хаанч лалын эхэн үед Ойрад тусгаар оршиж, Баруун гурван түмэн биеэ даасан байдалтай байжээ. Түмэн Засагт хаан Зүүн Монголын зүүн гурван түмний нэгэн болох Халх түмэнд төвлөж, Хархорумын ор суурин дээр гол өргөө ордоо байлгаж байгаад дараа нь мөнхүү зүүн гурван түмний нэгэн болох Цахарт аяны өргөө байгуулж, удтал суусан байна. Тухайн үед Халхыг ихээхэн хүч нөлөө бүхий Абтай хан захирч, Чингисийн тахилгат ордны найман цагаан гэр, хааны залгамжлах хан хөвгүүн Жононгийн захиргааны баруун гурван түмний Ордос түмэнд Хутагтай Сэцэн хунтайж, тус гурван түмний Түмэд түмэнд Алтан хан тус тус зонхилж байжээ. Түмэн Засагт хаан, Абтай хан, Алтан хан, Хутагтай Сэцэн хунтайж нарын зэрэг Монголын тэргүүний зарим зүтгэлтэн улс орны нэгдлийг сэргээн бэхжүүлэх талаар ихэд анхаарч, шинэлэг арга хэмээ авч байжээ. Тэр тухай Саган Сэцэний «Эрдэнийн эрхи» зэрэг түүхийн сурвалж бичигт хэсэг бусаг зүйл тусаж үлдсэн байдаг. Түмэн Засагт хааны үйл ажиллагааны зарим чухал зүйлийг 1966-1969 онд монгол түүхчдийн хамтран зохиосон «БНМАУ-ын түүх» гурван боть зохиол, 1985 онд Өвөр Монголын түүхч Лю Цзиньсогийн зохиосон «Монголын хураангуй түүх»<sup>3</sup> зэрэг зохиолд бузгай нарийвчлан оруулж, үнэлгээ өгсөн байгаа. Гэвч сурвалжийн дотор баримт ховор учир тухайн

асуудлаар тодорхой дүн шинжилгээ хийхэд бэрх бөгөөд санаа бодлын зөрөө аяндаа гарахад хүргэсээр ирсэн байна.

Монголын түүхийн судалгааны зарим бүтээлд феодалын бутралын үеийн Монгол улс төр, засаг засаглал бараг байхгүй болсон юм шиг үзэж, Монголын улс төр, засгийн төвийн үүргийг Түмэдийн Алтан ханы өргөө гүйцэтгэж, Алтан хан нийт Монголын хаан болох санаа агуулж байсан мэт болгоод Монголд буддын шашныг бараг гагцхүү Алтан хан санаачлан нэвтрүүлж, тэр талаараа тус орны түүхэнд харгис үүрэг гүйцэтгэсэн, ер нь буддын шашин, хүрээ хийд, лам хувраг туйлын харгис хүчин байсан гэсэн өрөөсгөл дүгнэлт хийх болсон нь цөөнгүй.

Түүхийн баримт, үнэн байдлыг нягтлахад феодалын бутралын үеийн Монгол улс нь зарим үед Зүүн, Баруун түмэн, Ойрад хэмээн хоёр, гурав хуваагдаж байсан боловч тэдгээр нь тус тусдаа биеэ даасан төр, засаг бүхий бэсрэгхэн төр улс буюу ханлиг байсан учир Монголд төр, улс засаг засаглал байхгүй болсон мэт үзэх үндэс алга. Тухайн үеийн Монгол улс нь хэд хэдэн жижиг улс буюу хант улсууд, ханлиг болж хуваагдсаны аль алинд Монголын төр ёсны уламжлал тасралтгүй хадгалагдан үлдсэн байв., Монгол улсын төрийн төв нь үндсэндээ улсын хааны өргөөнд төвлөрсөөр ирсэн юм. Тийм учир Монгол улс ба гадаад орнуудын хоорондын харилцааг авч үзэхэд мөн л ихэвчлэн Монголын хаан, гадаад улсын засгийн газрын харилцаа хоёрыг голлож анхаарах нь зүйтэй болов уу. Монголын зах хязгаарын аль нэг түмэн ба гадаад орны мужийн эрх баригчдын хоорондын харилцаа нь хоёр орны хоорондын харилцааны зөвхөн нэг хэсэг болохоос биш, гол нь Монгол улс ба гадаад орны төр, засгийн дээд эрхийг баригчдын хоорондын албан ёсны харилцаа байх ёстой мэт санагдана. Жишээлбэл, Мин улсын засгийн газраас Түмэдийн Алтан хантай харилцсаныг Монгол, Хятадын харилцаанд оруулан тооцохгүй байж болохгүй. Гэхдээ Монгол, Хятадын харилцааны гол шийдвэрлэх чиглэл нь өгүүлэгдэн бүхий үед тус хоёр орны хаад ба засгийн газруудын хоорондын албан ёсны шууд харилцаа байсан гэж үзэх нь зүйд илүү нийцэх биз ээ.

Монголын төрийн эрхийг Улсын хаан, жонон, түмний хан, тайш, зарим ихэс дээд ноёд барьж байсан. Түмэн Засагт хан төрийн гүйцэтгэх албыг төвлөрүүлэн цэгцэлж, засаг захиргааг чангатгах зорилгоор төв засгийн газрыг шинэчлэн байгуулсан юм. Тэрхүү засгийн газрыг хаан, жонон өөрсдөө толгойлж байсан нь мэдээж. Тэгэхдээ түүний бүрэлдэхүүнд зүүн, баруун түмний аль алинаас ихээхэн хүч нөлөө бүхий, чадвартай ноён, түшмэдийг татан оруулж байнга ажиллуулсан байна. Зүүн гурван түмнээс Амудай хунтайж. Халхын Субухай Үйзэн, баруун гурван түмнээс Ордосын Хутугтай Сэцэн хунтайж, Асудай Номдар Хулачи, Түмэдийн Амудай Чүрүхү хунтайж нарын зэрэг хүмүүс шинэ засгийн газрын удирдлагад оролцжээ.

Түмэн Засагт хаан бас өөрийн улсын нэгдмэл байдал, дотоодыг засан цэгцлэх зорилгоор зүүн, баруун зургаан түмний ноёдыг цуглуулж, төрийн их цаазыг шинэчлэн боловсруулж гаргасан гэдэг. Түмэн Засагт хааны шинэ их цааз нь Монголын төрийн үндсэн хуулийн шинжтэй болж, түүний дагуу бусад зарим түмний хан, ноёд тус тусын нутагт дагаж мөрдөх цааз хууль зохион гаргаж байжээ. Ихээхэн хүч нөлөө бүхий Түмэдийн Алтан хан хүртэл Түмэн Засагт ханы Их цаазын үндсэн дээр Түмэд түмэнд мөрдүүлэх тусгай нэгэн хууль зохиож, түүнийгээ бага цааз» хэмээн нэрлэж байжээ.<sup>4</sup>

Энэ бүхнээс үзвэл Түмэн Засагт хаан өөрийн хаанчлалын эхэн шатанд ч гэсэн ойрадаас бусад Монгол газар дээр төрийн эрхийг төвлөрүүлэн барьж, засаг засаглалыг нэг мөр болгон явуулж байсан гэлтэй.

Түмэн Засагт хаан зонхилж, Зүүн, Баруун түмний эрх баригчдын

үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, ажлын хуваарь бий болгосон байж магад байна. Түмэн Засагт хаан зүүн гурван түмнийг өөрөө шууд гардан захирч байсны хувьд нутгийн дөтөөр Монгол угсааны дагуур нарыг эрхшээлдээ оруулж аваад манж угсааны усны гурван зүрчидийг байлдан эзэлсэн байна. Халхын Абтай ханы харьяаны нутгийн баруун хойд захын Убаш хунтайж ойрадын умард хэсгийг хумьж авахаар цэрэглэн орж байжээ. Урьд нь Ойрадын өмнө хэсгийг эрхшээлдээ оруулсан Алтан хан Хөх нуурыг эзэлж аваад Оросын Хутугтай Сэцэн хунтайжийг тусгайлан илгээж Ойрадын бусад зарим аймгуудыг эргүүлж Монголд нэгтгүүлж байжээ. Үүний улмаас бид Түмэн Засагт хаан, Алтан хан хоёрын хооронд асар ноцтой зөрчил байсан гэж үзэх үндэстэй бөгөөд ялангуяа Алтан хан Түмэн Засагт хаантай эрх булаацалдаж, өөрөө улсын хаан болох далдын санаа өвөртөж байсан гэхэд, учир дутагдалтай.

Түмэн Засагт хаан бүхэл бүтэн нэг улсын төрийн тэргүүний хувьд хөгжмөл хүчирхэг Хятадын Мин улсын хувьд ихээхэн болгоомжлон сэрэмжилсэн, мэдэгдэхүйц биеэ даасан тусгаар тогтнолын хатуу зарчим баримталж байсан нь гайхалтай биш, Алтан хан ч гэсэн Мин улсын талаар дандаа найрамдлын бодлого явуулж, үргэлж буулт хийж байгаагүй, олон удаа түүний эсрэг довтолгоон үйлдэж, нийслэл хотод нь хүртэл тулж очиж байсан. Тийм учир нутгийн дөтөөр Алтан хан Хятадтай худалдаа арилжаа хийхийг оролдож, зөвхөн зарим үед арга буюу түүнд буулт хийж, найрамдан байсныг урван тэрсэлсэн мэт үзэж, Түмэн Засагт хааны эсрэг хандсан адил үзэх нь үнэн байдалд үл нийцнэ. Түмэн Засагт хаан чухамдаа Алтан ханыг тэглээ гэж шууд зэмлэсэн баримт байхгүй, харин Мин улсын засгийн газрыг өөрийн харьяаны этгээд болох Алтан хантай дур мэдэн, зоргоор харилцаж, ёс алдлаа гэж зэмлэж байсан нь Алтан хан. Түмэн Засагт хоёрын зөрчлийн асуудал биш, Монгол Хятадын харилцааны жич асуудал болью.

Тухайн үеийн Монгол улсын нэгдмэл байдал, нийгэм-эдийн засаг, нүүдэл иргэншлийн соёл болон гадаад харилцааны амьдрал, хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хуучин бөөгийн өргөл хангаж нэгэнт чадахаа больсон учир өв, шинэ шашин шүтлэг бий болгож хэрэглэхээс өөр аргагүй болсон байв. Монгол хаад, ноёд сурвалжит язгууртан нарын анхаарлыг Юан улсын үеэс Монголд нэвтэрч байсан уламжлал бүхий дээр үеийн танил буддын шашин зүй ёсоор татаж байжээ. Төвдөд буддын шашны хуучин улаан малгайтны ёс, шинээр бий болж, хүчийг олж байсан шар малгайтны суртал өвөр хоорондоо өрсөлдөн тэмцэлдэхдээ аль аль нь цэрэг-улс төрийн хүчирхэг уламжлал бүхийн дээр Төвдтэй адил төсөөт нүүдэл иргэншилтэй хуучин холбоотон монголчуудын дэмжлэгийг олохыг хичээж байсныг монгол хаад, ноёд анхаарахгүй байж болохгүй байв. Монгол хаад ноёд бас Монгол улсын дотоод эв нэгдлийг сэргээн бэхжүүлж, улс орноо хөгжүүлэх зэрэгт Төвдтэй шашин төрийн эвсэл холбоо байгуулах зорилгоор түүний шүтдэг буддын шашныг авч хэрэглэхээр шийдсэн байна. Буддын шашныг анх зөвхөн Алтан хан, Хутугтай Сэцэн хунтайж хоёр л гэнэт санаж сэдээд авсны дараа бусад монгол ноёд тэднийг дууриан дагаж авсан юм шиг ярих бичих явдал бий. Гэтэл Түмэн Засагт хаан анх 1576 оны улаан хулгана жил Төвдийн буддын шашны улаан малгайтны тэргүүн, илд зангидагч их лам Гармаа гэгчийг өргөө ордондоо залж ирүүлээд түүнд шавь орж, Цахар, Халх түмний зэрэг нийт монголчуудын дунд буддын шашин нэвтрүүлэн дэлгэрүүлэх ажил зохиосон тухай мэдээ байдаг.<sup>5</sup> Хэрэв ийм бол Түмэн Засагт ханы хамт буддын улаан малгайтны шашинд нэн түрүү Абтай хан зэрэг зүүн түмний бусад олон ноёд харьяат ардуудтайгаа цуг орсон байж таарна. Түмэн Засагт хаан чухамхүү улаан малгайтны тэргүүнийг урьж, түүнд шавь орсон нь санамсаргүй хэрэг

биш, яагаад гэвэл тухайн үеийн Төвд улсад, тэр шашны чиглэл эрт цагаас давамгайлж төрийн шашны шинж чанартай болсон байв.<sup>6</sup> Дараа жил нь 1577 онд Түмэдийн Алтан хан, Хутугтай Сэцэн хунтайж нар Төвдийн буддын шашны шар малгайтны тэргүүн, Зункавагийн (1357—1419) гурав дахь дүрийн хувилгаан Содномжамцыг залж (гуравдугаар) Далай лам цол өргөмжлөөд түүнтэй багш шавийн барилдлагаа барьж, Түмэд Ордосыг шарын шашинд оруулсан нь чухамдаа Түмэн Засагт хаантай санаа нийлэхгүй, өрсөлдөж зөрсөндөө биш болов уу. Монгол хаад, ноёд Төвдтэй шашин, төрийн эвсэл холбоо байгуулахын тул хамгийн нөлөө бүхий улаан, шар малгайтны аль алийг талдаа татаж, эцэстээ аль илүү ашигтай гэснээ бүрэн дэмжиж ашиглах бодлого баримтлан, ажлаа хуваарилж явуулсан бололтой байдаг. Учир нь Түмэн Засагт хааныг улааны шашинд орж байхад Алтан хан, Хутугтай Сэцэн хунтайж нар дургүйцээгүй, сүүлийн хоёрыг нарын шашинд орохыг Түмэн Засагт эсэргүүцээгүй байна. Түүгээр үл барам, Түмэн Засагт хаан, Абтай хан нар цаашдаа Далай ламд урилга заллага ирүүлж, нэн түрүү Цахар, Халхыг бас шарын шашинд оруулсан байдаг.<sup>7</sup> Мөн тэр үеэр Ойрадын Мэргэн Тэвнэ ноён өөрийн хүүг шарын шашинд оруулж, Төвдөд илгээн Лхасад 1580/90-ээд оныг хүртэл сургасан нь Нэйж тойн хэмээн алдаршиж,<sup>8</sup> Баруун Монголд шарын шашин нэвтрэн дэлгэрэхийн эх үүсвэр, салхич шувуун болсон юм. Тийнхүү Түмэн Засагт хаан, Абтай хан, Алтан хан, Хутугтай Сэцэн хунтайж. Мэргэн Тэвнэ нар Зүүн, Баруун түмэн болон Ойрадад шарын шашин нэвтрэн дэлгэрэх суурь тавьж, Монголыг үзэл суртал, соёлын аймагт буддын шарын шашнаар нэгтгэн жигдрүүлэх асуудлыг санаа нэгтэй шийдсэн нь тэдний дунд ноцтой зөрчил байсангүй, харин төрийн бодлогын ноён нуруу нь улсын хааны туг сүлдэн доор нэгдмэл чиг хандлагатай байсныг нотолж байна.

Дээр дурдсан бүх зүйлийн үндсэн дээр доорх дүгнэлтүүдийг гаргаж болмоор санагдана. Үүнд:

1. Тухайн үеийн Монгол улсын нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлэх зорилтын гол санаачлагч, зохион байгуулж хэрэгжүүлэгч нь Түмэн Засагт хаан байсан. Төр, засаг, цааз хууль, шашин шүтлэг, цэрэг дайны шинэ арга хэмжээний олонх нь түүний шийдвэрлэх чиглүүлэг шууд оролцоотой хийгдсэн.

2. Абтай хан, Алтан хан, Хутугтай Сэцэн хунтайж нарын зэрэг дэвшилтэй хан, ноёд улс орны амьдрал, хөгжлийн зангилаа асуудлууд дээр Түмэн засагт хаантай үндсэндээ санаа нийлж, түүнийг дэмжсэн.

3. Дотоод, гадаад бодлогын асуудал дээр Түмэн Засагт хаан тэднийг удирдан, үйл ажиллагааг нь зохицуулж байсан талтай.

4. Алтан хан Хятад ч бууж өгч, дагаар ороогүй, Монголын төрийн эрх, хаан ширээнд ч санагалзаж байгаагүй, харин шарын шашин Монголд нэвтрэн дэлгэрэхэд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн.

5. Буддын шашныг Монголд нэвтрүүлэн дэлгэрүүлэхийг анх санаачилж, удирдан зохиох байгуулсан гол этгээд нь Түмэн Засагт хаан өөрөө байв.

6. Буддын шашныг Монгол улсын төрийн тусгаар тогтнол, улс орны нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлж, нүүдэл иргэншлийн цаашдын дэвшил хөгжлийг түргэсгэх, Төвдтэй шашин, төрийн эвсэл холбоо байгуулж, гадаад байдлаа бэхжүүлэх зорилгоор авсан.

7. Буддын шашин Монголын түүхэнд дэвшилт үүрэг гүйцэтгэсэн.

8. Түмэн Засагт хаан Монгол улсын төрийн нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлж, улс орны амьдрал, хөгжлийг цэгцлэн жигдрүүлэх зорилтыг нэлээд хэмжээгээр биелүүлж, санасан санаандаа үндсэндээ хүрсэн болно.

## АШИГЛАСАН НОМ, ЗОХИОЛ

1. «БНМАУ-ын түүх» тэргүүн боть, УБ, 1966, 419—420-р тал
2. Саган Сэцэн, Хаадын үндэсний Эрдэнийн товч, Бээжин-Хөх хот, 1962, 63-67-р тал
3. Лю Цзинсо, Монголын хураангуй түүх, Бээжин-Хөх хот, 1985, 185—193-р тал:
4. Мөн зохиол. 191-р тал
5. Саган Сэцэн, хаадын үндэсний эрдэнийн товч, Бээжин-Хөх хот, 1962, 68-р тал
6. Helmut Hoffmann, Tibet, Bliimington, 1975. pp. 56—56
7. Саган Сэцэн. Дурьдсан зохиол 79-р тал
8. Ойрад түүхэн сурвалж, Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ эмхтгэн тайлбарлав. Хөх хот, 1985, 68-р тал